

Монголбанкны Хяналт шалгалтын газрын захирал Б.Лхагвасүрэн:

**САНХҮҮГИЙН СИСТЕМ ӨНДӨР ӨСӨЛТТЭЙ БАЙНА, ГЭХДЭЭ ӨНДӨР ӨСӨЛТ
ӨНДӨР ЭРСДЭЛ ДАГУУЛДГИЙГ МАРТАЖ БОЛОХГҮЙ**

Өнөөдрийн байдлаар Монголын банкны салбарын биеийн байдал ямаршуу байна вэ?

-Монгол улс банк давамгайлсан санхүүгийн зах зээлтэй улс юм. Санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдлыг үндсэнд тодорхойлж байгаа банкны салбар маань санхүүгийн зах зээлийнхээ 85 хувийг эзэлж байгаа бөгөөд үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байгаа гэж дүгнэж болохоор байна. Монголбанкны зүгээс арилжааны банкуудын хэвийн үйл ажиллагаа, системийн тогтвортой байдлыг хангуулах үүднээс байнга хяналт тавин ажиллаж ирсэн. 2009 оноос хойш банкуудын санхүүгийн эх үүсвэр болон зээл, өөрийн хөрөнгө их хурдацтай өсөж байна. Олон нийтээс банкинд итгэх итгэл өндөр байгаагийн нэг илрэл нь жил бүр банкны харилцах хадгаламжийн хэмжээ 60-аас дээш хувьтай өсч байгаа явдал. Үүний хэрээр банкны төлбөрийн гүйцэтгэх чадвар нэмэгдэн, зээл гаргах хэмжээ нь ч өсч байна. Ийнхүү хурдацтай өсч байгаа нь банкны салбар хямралын хүнд үеийг ардаа орхиж, эдийн засгийн өндөр өсөлтийг дэмжин санхүүгийн зуучлалаа өргөжүүлэн нэмэгдүүлж байгаагийн илрэл болж байгаа хэдий ч өндөр өсөлт эрсдэл дагуулдаг гэдгийг санах хэрэгтэй. Үүнийг ч олон улсын санхүүгийн байгууллагын мэргэжилтнүүд сануулж байгаа.

-Банкны салбарт сүүлийн үед хийгдэж буй томоохон төсөл хөтөлбөрийн нэгд шинээр мэндлэх гэж буй хадгаламжийн даатгалын хууль зүй ёсоор орох болов уу?

-Банкны бизнес итгэл дээр суурилдаг бизнес учир олон нийтийн зүгээс банк, санхүүгийн системд итгэх итгэл нь банк төдийгүй санхүүгийн зах зээлийн тогтворой байдалд чухал ач холбогдолтой.

Олон нийтийн итгэлийг алдахгүй байх, өндөр байлгах санхүүгийн олон арга хэрэгслэлүүд байдгийн нэг нь хадгаламжийн даатгалын тогтолцоо бөгөөд дэлхийн олон улс орнууд авч хэрэгжүүлсэн, нийтлэг жишиг болсон арга хэмжээ юм. 2008 оны арванхоёрдугаар сард УИХ-аас хадгаламжийн баталгааны хуулийг батлан мөрдүүлсэн нь цагаа олсон, чухал арга хэмжээний нэг болсон бөгөөд бас л нэг төрлийн арга хэрэгсэл юм.

Тухайн үед дэлхий нийтийг хамарсан санхүү, эдийн засгийн хямрал монголын банк, санхүүгийн системийг нэлээд хүчтэй доргиож, хоёр ч банк дампуурч татан буугдсныг хүмүүс мартаагүй байгаа байх. Мөн тухайн үед банкны харилцагч хадгаламж эзэмшигчдийн зарим нь хадгаламжаа татах хүртэл арга хэмжээ авч байсан. Үүнийг зогсоох олон нийтийн банкинд итгэх итгэлийг нэмэгдүүлэх үүднээс хадгаламжийн баталгааны хуулийг баталсан бөгөөд энэ нь хямралын хүнд үеийг давах үүднээс авсан түр зуурын арга хэмжээ болно. Энэхүү хуулийн үйлчлэл нь дөрвөн жилийн хугацаатай хэрэгжихээр гарч 2012 оны арваннэгдүгээр сард дуусна. Иймээс энэхүү түр арга хэмжээг орлох дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн сонгодог тогтолцоог бий болгох шаардлагын дагуу хадгаламжийн даатгалын хуулийн төслийг Монголбанкнаас боловсруулж, засгийн газраар дамжуулан УИХ-д өргөн бариад байна. Хадгаламжийн даатгалын хуулийг гаргаж сонгодог тогтолцоог бий болгосноор банк харилцагчийнхаа,

хадгаламж эзэмшигчийнхээ өмнөөс даатгал хийлгэж хамгаалах тогтолцоо бий болж төлөвших болно.

-Хадгаламжийн даатгалын хуульд даатгалын шимтгэлийг хэн төлөхөөр тусгагдсан бэ? Арилжааны банк уу, хадгаламж эзэмшигч үү?

-Шимтгэлийг банк төлнө. Банкинд мөнгөө хадгалуулсан хүн бол ямар нэг илүү зардал гарган шимтгэл төлөхгүй. Харин итгэж мөнгөө хадгалуулсан харилцагчийнхаа хадгаламжийг банк нь тусгай зориулалт бүхий төрийн мэдлийн мэргэжлийн даатгалын байгууллагад даатгуулан, таны өмнөөс шимтгэлээ төлье гэх зарчмаар явагдана. Тухайн даатгалын байгууллага нь шимтгэл, хураамжаар хөрөнгөө арвижуулан, хүндрэл бэршээлтэй үед даатгалын тохиолдол гарахад тодорхой хязгаарын хүрээнд нөхөн олговор олгох замаар хохиролыг барагдуулах байдлаар үйл ажиллагаагаа явуулах юм. Өнөөдрийнх шиг бүх зүйл төрийн нуруунд үүрэгдэхгүй, татварын мөнгөөр хохирол барагдуулах асуудлыг үүсгэхгүй байхаар зохицуулагдах болно.

-Иргэдийн дунд багагүй төөрөгдөл байна. ХААН банкны ирээдүй хэцүүхэн байгаа гэдэгт та ямар хариулт өгөх вэ?

-Иргэдийн хувьд энэ банкнаас айж болгоомжлох зүйл байхгүй гэдгийг хэлэх байна. Учир нь тус банк манай гурван том арилжааны банкны нэг. Системд нөлөө бүхий томоохон банкуудад Монголбанкны хяналт шалгалт илүү хэмжээтэйгээр хийгддэг төдийгүй өндөр шаардлагыг тавьдаг. Тухайлбал бусад банкууд өөрийн хөрөнгийн зохистой харьцааг 12 хувьд барих шаардлагатай бол системийн нөлөө бүхий банкууд хувьд 14 хувь байлгах ёстой гэсэн өндөр ачааллыг шаардаж байдаг. ХААН банкны хувьд Монгол улсын аймаг сум бүрт салбартай, гадаад дотоодын хөрөнгө оруулагч олонтой учраас итгэл алдрах зүйл байхгүй гэж хэлмээр байна. Хамгийн муу байдлаар төсөөлөхдөө ч гэсэн гадна дотны томоохон хөрөнгө оруулагчид нь зүгээр суухгүй, тэдний хувьд тийм эрсдэл хүлээх зүйл хийхгүй нь ойлгомжтой.

-Монголбанк сая гарсан алттай холбоотой асуудалд буруутай эсвэл өөрсдөө хохирогч болчихсон ч юм шиг элдэв мэдээлэл хэвлэлээр цацагдаад байгаа. Энэ талаар?

- Монголбанк алтыг худалдан авахдаа албан ёсоор сорьцын баталгаа хийдэг эрх бүхий ганц л байгууллагын баталгаажилтыг харж авдаг бөгөөд засгийн газрын харьяа агентлаг Стандартчилал хэмжил зүйн газрын сорьцын хяналтын албаар баталгаажин ирдэг. Сорьц тогтоолгоод ирсэн алтыг дахин сорьц тогтоох ч юмуу ямар нэг аргаар өөрчлөн, өөр металтай хольж хутгах үйлдвэрлэл Монголбанк дээр явагддаггүй. Цэвэршүүлэх ажлыг Монголбанк биш гадаадын нэр хүнд бүхий тусгай байгууллага хийдэг. Ийнхүү хайлуулах явцад манайхаас ачуулсан алтны сорьц зөрүүтэй гарсан учраас Монголбанк хууль хяналтын байгууллагад өөрөө хандсан. Үүнийг хууль хяналтынхан тогтоохоор ажиллаж байгаа.

-Монголбанкнаас гурван ажилтан хоригдон, шалгагдаад байгаа юмуу?

-Одоогоор манай ажилтнуудаас гурван хүнийг саатуулан шалгасан гэсэн асуудал байхгүй. Эрдэнэсийн сангийн нэг ажилтныг саатуулан шалгаж байгаа нь гэсэн мэдээлэлтэй байна. Хуулийн байгууллага л үүнд тодорхой хариулт өгөх байх.